



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/40

Дуурсах

Олон нийтэд түшиглэсэн нялх,
бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө
өгөгч бэлтгэх сургалт зохион байгуулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21 дүгээр заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Заавар батлах тухай” А/481 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөгч бэлтгэх” сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 23-27, 06 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд хоёр ээлжээр зохион байгуулсугай.
2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Сургалтад зарцуулагдах 24.030,520 (Хорин дөрвөн сая гучин мянга таван зуун хорин) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн зардлаас зарцуулахыг Ахлан нягтлан бодогч (П.Мөнх-Эрдэнэ) -д зөвшөөрсүгэй.
4. Сургалтыг чанартай, үр дүнтэй зохион байгуулан тайлагнахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (С.Батцэцэг), Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн (Д.Мөнх-Эрдэнэ), Өсвөр үе, нөхөн үржихүйн асуудал хариуцсан мэргэжилтэн (М.Баярбаясгалан) нарт тус тус үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв (Д.Балжмаа)-д даалгасугай



ДАРГА

Н.ЭНХЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын *А.Н.Э.* оны
...05... дугаар сарын ...19... -ны өдрийн
А.Н.Э. тушаалын нэгдүгээр хавсралт

**“ОЛОН НИЙТЭД ТУШИГЛЭСЭН НЯЛХ,
БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛЛОЛТЫН ЗӨВЛӨГӨӨ
ӨГӨГЧ БЭЛТГЭХ” СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй хөгжил” хөтөлбөрийг 2018 оноос хэрэгжүүлэн ажилласнаар тус онд хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөд 11.5 промилл байсан бол 2021 онд 8 болж, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 15 байсан бол 5 болж буурсан, 0-5 хүртэлх насны тураалтай (-3sd) 7 хүүхэд, туранхай (-3sd) 9 бүртгэгдэн эмчлүүлж байсан бол 2021 онд тус бүр 1 бүртгэгдэн эмчүүлсэн.

2021 оны эхийн сүүгээр хооллолтын үзүүлэлтийг дүгнэвэл төрсний дараа 1 цагийн дотор ангир уургаар амлуулалт 96.3 хувь, улсын дунджаас 4.1 хувиар өндөр, 0-6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллолт 73.1 хувь, улсын дунджаас 22.9 хувиар өндөр, 06-23 сар хүртэл эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллолт 74.1 хувь, улсын дунджаас 5.1 хувиар өндөр, нялхсын сүүн тэжээлийн хэрэглээ 5.6 хувь, улсын дунджаас 5 хувиар бага зэрэг эерэг үзүүлэлтүүд гарсан хэдий ч ҮСХ-оос 2019 онд зохион байгуулсан “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа”-аар 06-23 сартай хүүхдийн 64.1 хувь нь зохих давтамжтай хооллож байгаа нь улсын дунджаас 1.8 хувиар бага, 21 хувь нь зохих нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж байгаа нь улсын дунджаас 18.2 хувиар бага сөрөг үзүүлэлттэй байна.

Иймд шинээр төгсөж ирсэн эмч, мэргэжилтнүүдийг нялх бага насны хүүхдийн хооллолтын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэн, зөвлөгөө өгөх ур чадварт сурган зөвлөгөө өгөгчийн тоог нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хоёр. Сургалтын зорилго

Эмч, мэргэжилтнүүдийг нялх, бага насны хүүхдийн хооллолтын талаарх онолын мэдлэгийг нэмэгдүүлэн зөвлөгөө өгөх өгөх ур чадварт сургахад сургалтын зорилго оршино.

Эрүүл мэндийн газрын даргыноны
 ..05 дугаар сарын 19..... -ны өдрийн
 А/40 тушаалын хоёдугаар хавсралт

ОЛОН НИЙТЭД ТУШИГЛЭСЭН НЯЛХ,
 БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛЛОЛТЫН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨГЧ БЭЛТГЭХ”
 СУРГАЛТЫН НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ХӨТӨЛБӨР

Хугацаа	Сэдэв, агуулга	Сургагч багш	
		I танхим ЭМГ-ын сургалтын танхим /15 оролцогч/	II танхим НЭ-ийн сургалтын танхим /15 оролцогч/
1	2	3	4
2022.05.23			
08:00-08:20	Сургалтын нээлт	ЭМГ-ын дарга Н.Энхжаргал	
08:20-11:00	Хичээл 1: Танилцуулга, сургалтын өмнөх үнэлгээ, сургалтын дүрэм, бүлгийн хуваарьлалт, хүлээгдэж буй үр дүн, зорилтууд Хичээл 2: НБНХХ яагаад чухал болох	С.Батцэцэг С.Алтанхуяг	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан
11:00-11:15	Цайны завсарлага		
11:15-13:00	Хичээл 3: Нялх бага насны хүүхдийн хооллолтод нөлөөлөх түгээмэл тохиолдлууд Хичээл 4 : Хэрхэн зөвлөгөө өгөх вэ ? I хэсэг -Сонсох ба ойлгох ур чадварууд -Зан үйлийг өөрчлөх үе шатууд	М.Тоджаргал С.Алтахуяг	Ж.Амарзаяа Ч.Өлзийжаргал
13:00-14:00	Үдийн завсарлага		
14:00-16:00	Хичээл 5: НБНХХ-ын талаарх зөвлөмж, эхийн сүүгээр хооллолт	М.Тоджаргал С.Алтахуяг	Ж.Амарзаяа Ч.Өлзийжаргал
16:00-16:15	Цайны завсарлага		
16:15-16:45	Хичээл 6: Эхийн сүүгээр хэрхэн хооллох вэ ? -Хөх яаж ажилладаг вэ? -Хүүхдийг хөхүүлэх зөв байрлал, хөхийг зөв үмхүүлэх	М.Тоджаргал С.Алтанхуяг	Ж.Амарзаяа Ч.Өлзийжаргал
2022.05.24			
08:00-11:00	Хичээл 7: НБНХХ-ын талаарх зөвлөмж, 06-23 сартай хүүхдийн нэмэгдэл хооллолт	С.Батцэцэг С.Алтанхуяг	Ж.Амарзаяа Ч.Өлзийжаргал
11:00-11:15	Цайны завсарлага		
11:15-13:00	Хичээл 8: Хүүхдийн нэмэгдэл хоол Хичээл 9: Хэрхэн зөвлөгөө өгөх вэ ? II хэсэг	С.Батцэцэг С.Алтанхуяг	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан

Гурав. Зорилт

Сургалтад оролцогчдын

- Эхийн сүүгээр хооллолтын дадлуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх.
- 06-23 хүртэлх сартай хүүхдийн нэмэгдэл хооллолтын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх.

- Эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн талаар мэдлэгийг нэмэгдүүлэх.

- Өвчтэй хүүхдийн хооллолтын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх.

-ХДХВ-ийн халдварын үеийн НБНХХ-ын талаар мэдлэг эзэмшүүлэх.

Сургалтад оролцогчдыг

-Нялхас бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх ур чадварт сургах.

-Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах аргачлалд сургах.

Дөрөв. Хамрах хүрээ, хамрагдагч Эрүүл мэндийн газар-6, Нэгдсэн эмнэлэг-6, СЭМТ-40, ӨЭМТ-8, нийт 60 эмч, мэргэжилтнүүд хамрагдана.

Тав. Хугацаа: 2022 оны 05 дугаар сарын 23-27, 06 дугаар сарын 06-10 хугацаанд тус бүр 2 ээлж, 4 анги болон хичээллэнэ.

Зургаа.Хаана: Эрүүл мэндийн газрын сургалтын танхим, Нэгдсэн эмнэлгийн сургалтын танхимд хуваарийн дагуу

Долоо. Хүрэх үр дүн

Сургалтад оролцогчдын

- Эхийн сүүгээр хооллолтын дадлуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

- 06-23 хүртэлх сартай хүүхдийн нэмэгдэл хооллолтын талаарх мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

- Эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн талаар мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

- Өвчтэй хүүхдийн хооллолтын талаар мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

-ХДХВ-ийн халдварын үеийн НБНХХ-ын талаар мэдлэгийг нэмэгдүүлсэн байна.

Сургалтад оролцогчид

-Нялхас бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх ур чадварт суралцсан байна.

-Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах аргачлалд суралцсан байна.

	-НБНХХ-ын зөвлөгөө өгөх 3 үе шат -Итгэл төрүүлж, дэмжлэг үзүүлэх ур чадварууд -Хүүхдийн хооллолтын үнэлгээний маягыг ашиглах		
13:00-14:00	Үдийн завсарлага		
14:00-16:00	Хичээл 9: Үргэлжлэл Хичээл 10: Эхийн сүүгээр хооллолтын түгээмэл бэрхшээл	М.Тоджаргал С.Алтанхуяг	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан
16:00-16:15	Цайны завсарлага		
16:15-16:45	Хичээл 10: Үргэлжлэл, ӨЭМТ-д дадлага хийх бэлтгэл	М.Тоджаргал С.Алтанхуяг	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан
2022.05.25			
08:00-11:00	ӨЭМТ- д дадлага	Ч.Өлзийжаргал М.Баярбаясгалан	С.Алтанхуяг Ж.Амарзаяа
11:00-11:15	Цайны завсарлага		
11:15-13:00	Хичээл 11: ӨЭМТ-д хийсэн дадлага, үр дүнгийн талаар санал солилцох.	С.Батцэцэг С.Алтанхуяг	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан
13:00-14:00	Үдийн завсарлага		
14:00-16:00	Хичээл 12: Яаж гүйцэтгэх вэ ? *Үйл ажиллагаанд чиглэсэн бүлгийн уулзалт -НБНХХ-ын дэмжих бүлэг -Гэрийн эргэлт *Олон нийтийн хяналтын аргыг ашиглах -Үйл ажиллагаанд чиглэсэн бүлгийн уулзалт -НБНХХ-ыг дэмжих бүлгийн уулзалт	С.Батцэцэг С.Алтанхуяг	Ж.Амарзаяа Ч.Өлзийжаргал
16:00-16:15	Цайны завсарлага		
16:15-16:45	ӨЭМТ- д дадлага хийх бэлтгэл	М.Баярбаясгалан М.Тоджаргал	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан
2022.05.26			
08:00-11:00	Хичээл 13: ӨЭМТ-д дадлага -НБНХХ-ын үнэлгээ -Үйл ажиллагаанд чиглэсэн бүлгийн уулзалт -НБНХХ-ыг дэмжих бүлэг -НБНХХ-ын үнэлгээ	С.Батцэцэг С.Алтанхуяг	М.Тоджаргал Ч.Өлзийжаргал
11:00-11:15	Цайны завсарлага		
11:15-13:00	ӨЭМТ-д хийсэн дадлага, үр дүнгийн талаар санал солилцох.	С.Батцэцэг С.Алтанхуяг	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан
13:00-14:00	Үдийн завсарлага		
14:00-16:00	Хичээл 14: Эмэгтэйчүүдийн хоол тэжээл Хичээл 15: Өвчтэй хүүхдийн хооллолт	М.Тоджаргал С.Алтанхуяг	Ч.Өлзийжаргал М.Баярбаясгалан
16:00-16:15	Цайны завсарлага		

16:15-16:45	Хичээл 15: Үргэлжлэл	М.Тоджаргал С.Алтанхуяг	Ч.Өлзийжаргал М.Баярбаясгалан
5 дахь өдөр-2022.05.27			
08:00-11:00	Хичээл 16: ХДХВ-ийн халдварын үеийн хооллолт нялхсын	М.Тоджаргал М.Баярбаясгалан	Ж.Амарзаяа Ч.Өлзийжаргал
11:00-11:15	Цайны завсарлага		
11:15-13:00	Хичээл 17: НБНХХ-ын дэмжлэгийг ЭМАШ-ны тусламж үйлчилгээтэй уялдуулах нь Хичээл 18: -Сургалтын дараах үнэлгээ -Сургалтын үнэлгээ	С.Батцэцэг С.Алтанхуяг	М.Тоджаргал Ч.Өлзийжаргал
13:00-14:00	Үдийн завсарлага		
14:00-16:00	Хичээл 19: Ажлын төлөвлөгөө -Үйл ажиллагааны хүрээ -Төлөвлөгөөг танилцуулах	С.Батцэцэг С.Алтанхуяг	Ж.Амарзаяа М.Баярбаясгалан
16:00-16:15	Цайны завсарлага		
16:15-16:45	Сургалтын хаалт	ЭМГ-ын дарга Н.Энхжаргал	

Эрүүл мэндийн газрын даргыноны
 ...05...дугаар сарын ...19...-ны өдрийн
 А/Н/О тушаалын гуравдугаар хавсралт



**ОЛОН НИЙТЭД ТҮШИГЛЭСЭН НЯЛХ,
 БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛЛОЛТЫН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨГЧ БЭЛТГЭХ”
 СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Нэр төрөл	Тоо	Хэмжих нэгж	Давтамж	Нэг бүрийн үнэ /₮/	Нийт шаардагдах үнэ /₮/
1	2	3	4	5	6	7
1	Оролцогчдын бичиг хэргийн зардал	60	Ширхэг	1	7000	420000
2	Оролцогчдын томилолтын зардал	40	Хүн /өдөр	6	50000	12000000
3	Зохицуулагчийн ажлын хөлс	10	Хүн/хоног	1	30000	300000
4	Багшийн ажлын хөлс	2	Хүн/цаг	80	20000	3200000
5	Оролцогчдын замын зардал	40	Хүн/тариф	2	-	3324520
6	Оролцогчид багш нар, зохицуулагчийн цайны зардал	66	Хүн /цай	10	6000	39600000
Хичээлийн хэрэглэгдэхүүн						
7	Самбарын үзэг	10	Ширхэг	1	3000	30000
8	Бичгийн цаас	8	Боодол	1	20000	160000
9	Жижиг скоч	8	Ширхэг	1	1500	12000
10	Том скоч	8	Ширхэг	1	3000	24000
11	Бүлгийн ажлын цаас	15	Ширхэг	1	20000	300000
12	Сургалтын сертификатын төлбөр	60	Ширхэг	1	5000	300000
Нийт						24030520